



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 11/01

Эрдэнэт

Санхүүгийн аудитын дүнтэй холбогдуулан
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн тухай Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандахын илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Аудитын дүнгээр хүргүүлсэн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, дүнг IV дүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор /Ц.Нармандах/-т даалгасугай.

Хоёр.Аймгийн Засаг дарга Д.Батлутаг ДААЛГАХ нь:

2.1.Төсвийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэн, төсвийг бодитой төлөвлөж, авлага, өр төлбөр үүсгэхгүйгээр хэмнэлттэй үр дүнтэй зарцуулж, гүйцэтгэлд үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлэх.

2.2.Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилган, давтан гаргуулахгүй байх, төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, төсвийн сахилга батыг сайжруулах.

2.3.Аудитын дүнгээр хүргүүлсэн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллах.

ДАРГА  Т.ПҮРЭВЛХАГВА



0010286